



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/337

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол улсын Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2 дахь хэсгийн 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Гавьяат эмч Л.Эрдэнэцэцэгийг угтан авах зардалд 650,000 төгрөг, Шилдэг сувилагч батламж хийлгэхэд 280,000 төгрөг, Галданбошгот хааны дугтуй, марк авах зардалд 81,000 төгрөг, Өргөмжлөл, жуух бичгийн хавтас, бэлдэц хийлгэх зардалд 604,000 төгрөг, Аварга хээр морины хөшөөний нээлтэд өргөмжлөл хийлгэхэд 100,000 төгрөг, Монгол хэл, бичгийн сургалтын цайны зардалд 240,000 төгрөг, Хуралдааны арга хэмжээний зардалд 193,400 төгрөг, НҮБ-ийн Хүүхдийн сангийн суурин төлөөлөгч Аяако Кайно тэргүүтэй төлөөлөгчид аймагт ажиллах зардалд 1,001,040 төгрөг, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Элчин сайдын яам, Сэргээн босголт, зээлийн банк, Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хүмүүс аймагт ажиллах зардалд 1,936,300 төгрөг, Улаан сарнай киноны нээлтийн арга хэмжээний зардалд 500,000 төгрөг, Татварын мэргэшсэн зөвлөлийн нийгэмлэгээс зохион байгуулсан сургалтын зардалд 136,000 төгрөг, "Шинэ Ховд" шинэ суурьшлын бүсийн нээлтийн арга хэмжээний зардалд 464,000 төгрөг, Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтын ажиллагааны дарга Стефани Бурригийн уулзалтын зардалд 576,000 төгрөгийг баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 6,761,740 төгрөг (зургаан сая долоон зуун жаран нэгэн мянга долоон зуун дөч)-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д зөвшөөрсүгэй.

8407 71 1544
А/337

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д үүрэг болгосугай.



Б.ДҮГЭРЖАВ